

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭРЭГЦЭЭ ХАНГАЛТАД ХИЙСЭН СУДАЛГАА

Б.Эрдэнэхүү

Шүүх шинжилгээний ерөнхий газрын
Аюулгүй байдал, дотоод хяналт,
аудитын газрын чиглэлийн ахлах
мэргэжилтэн, докторант цагдаагийн
дэд хурандаа

Хураангуй: Шүүх шинжилгээ нь дотроо олон салбар бүхий цогц шинжлэх ухаан байдлаар хөгжиж байна. Шинжлэх ухааны оролт амжилтыг хууль сахиулах, тус тус гэмт хэргийг илрүүлэн тогтооход өргөн ашигладаг ба шинжилгээ хийдэг мэргэжлийн тусгай мэдлэгтэй шинжээчид шаардлагатай талаар судалж тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэсэн дүгнэлт, саналыг судалгааны үндсэн дээр дэвшүүлэн гаргахын зорилго.

Түлхүүр үгс: Шинжээч, тусгай мэдлэг, хүний нөөц.

Оршил: Аливаа байгууллага, түүний дотор төрийн байгууллагын өмнөө тавьсан зорилго, зорилтоо ханган биелүүлэх, амжилттай ажиллах чухал нөхцөлийн нэг нь яахын аргагүй хүний нөөцийн удирдлага, түүний бодлого, төлөвлөлтийн асуудал байдаг. Хүний нөөц нь байгууллагын бусад нөөцтэй харьцуулахад шавхагдашгүй арвин баялаг зүйл юм. Хүний нөөцийг зөв удирдан зохион байгуулж, төлөвлөж, хөгжүүлж чадвал үр бүтээлтэй ажиллахын зэрэгцээ, түүний бүтээлч чадамж бодитоор илэрч, улмаар байгууллага олон талт үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, өмнөө тавьсан ирээдүйн стратеги зорилгодоо хүрэх боломж бүрдэнэ.

Иймээс төрийн албаны хүний нөөцийн бодлого, түүн дотроо шүүхийн шинжилгээний байгууллагын хүний нөөцийн бодлогод онцгой анхаарч, түүнийг удирдлагын шинжлэх ухааны үндэслэлтэй боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Иймд уг асуудлыг бодлогын түвшинд авч үзэж чадварлаг алба хаагчдын залгамж халааг бэхжүүлж, шүүхийн шинжилгээний байгууллагад ажиллах хүний нөөц, тэднийг сонгох, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, дадлагажуулах, тэдэнд үзүүлэх нийгмийн дэмжлэг тусалцааг үндэслэлтэй тодорхойлох хэрэгцээ шаардлага бий болж, улмаар энэ асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх нь уг сэдвийг судлах үндэслэл, түүний хэрэгцээ шаардлагыг харуулж байна.

Үндсэн хэсэг

Шүүхийн шинжилгээний байгууллага нь ямар төрлийн тусгай мэдлэгтэй шинжээч байгаагаас шалтгаалж шинжилгээний төрөл нэмэгдэж байдаг хүний нөөцөө төрөл мэргэжлийн тусгай мэдлэг бүхий шинжээчээр бүрдүүлбэл тухайн байгууллагын хийх шинжилгээний төрөл, хүчин чадал тэр хэмжээгээр нэмэгдэх юм.

Ийм учир шинжилгээний байгууллагын хүчин чадлыг тодорхойлохын тулд хийж буй шинжилгээний төрөл болон түүнийг хийх тусгай мэдлэг, мэргэжил бүхий шинжээчтэй холбон авч үзэх шаардлага тулгараад байна.

“Шүүх шинжилгээ нь нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах шинжлэх ухааны баталгаа болно.”⁴¹ гэж эрхэм зорилгоо тодорхойлсон.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2018 оны 06 сарын 06-ны өдрийн А/06 дугаартай тушаалаар Шүүхийн шинжилгээний байгууллагын “Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийн баталсан.

Бодлогын баримт бичгийн зорилго:

Шүүхийн шинжилгээний байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх сонгон шалгаруулах өнөөгийн хүний нөөцийг үнэлэх, ирээдүйн хэрэгцээг тодорхойлох, түүнд хүрэхэд учирч болох эрсдэлийг тооцоолох, албан хаагчдын ур чадварыг нээн илрүүлж, чадварлаг тогтвор суурьшилтай боловсон хүчин бий болгоход оршино.

Тухайлбал 1993 онд ЦЕГ-н даргын тушаалаар⁴² КШТ-ийн орон тоог шинэчлэн, нийт 34 алба хаагчтай байхаар баталсан үүнээс хойш 1998 онд бүтцийн өөрчлөлт⁴³ хийснээр КШТ лабораторийн системд шилжих эхлэл тавигдсан бөгөөд гарын мөрний болон тусгай шинжилгээний лабораториуд бие даасан нэгжийн зохион байгуулалтад орсон бол 1999 онд дахин бүтцийн өөрчлөлт хийж албаны нохойн тасгийг КШТ-д шилжүүлсэн, үүний зэрэгцээ дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн дэргэд шинжилгээний лабораториудыг байгуулж эхэлсэн⁴⁴ байдаг.

Бүтэц, орон тооны шинэчлэлт

- ▶ 2005 оны 148 дугаар тушаалаар 148,
- ▶ 2009 оны 21 дүгээр тушаалаар 375,
- ▶ 2011 оны 43 дугаар тушаалаар 517,
- ▶ 2013 оны б/01 дүгээр тушаалаар 517, шинжээч албан тушаал дээр 275 орчим


⁴¹ Шүүх шинжилгээний байгууллагын эрхэм зорилго.

⁴² ЦЕГ-ын даргын 1993 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 128 тоот тушаал.

⁴³ ЦЕГ-ын 1998 оны а/23 тоот тушаал.

⁴⁴ ЦЕГ-ын 1998 оны а/77 тоот тушаал.

- ▶ 2015 оны А/23 дугаар тушаалаар 514,
- ▶ 2016 оны А/42 дугаар тушаалаар 514, шинжээч албан тушаал дээр 280 орчим байна.
- ▶ 2020 оны А/216 дугаар тушаалаар 594,
- ▶ 2022 оны А/146 дугаар тушаалаар 623,
- ▶ 2023 оны А/146 дугаар тушаалаар 723,
- ▶ 2023 оны А/274 дугаар тушаалаар нэмэлт 841 тооны хүний нөөцтэй баталсан байна.



№1 Шүүх шинжилгээний статистик⁴⁵

Дээрх статистик судалгааны харьцуулалтаас харахад тодорхой хэмжээгээр бүтэц орон тоо нэмэгдсэн байна.

ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИУД



⁴⁵ Шүүх шинжилгээний статистик 2022.

Мэргэжлээр нь авч үзвэл:

Криминалистикийн шинжилгээний газар

- ❖ *Эрх зүч-криминалистикийн шинжээч*
- ❖ *Авто техникийн инженер*
- ❖ *Материал судлал технологич инженер*
- ❖ *Физикч*

Байгалийн ухааны шинжилгээний газар

- ❖ *Хүнсний химич, агро химич, Экологийн химич, хөрсний химич*
- ❖ *Молекул биологи генетикч*
- ❖ *Био анагаах судлаач их эмч /бактериологич/*
- ❖ *Цөмийн физикч*
- ❖ *Хүний их эмч*
- ❖ *Рентген техникч*
- ❖ *Экологи*

Шүүх анагаах ухааны шинжилгээний газар

- ❖ *Хүний их эмч*
- ❖ *Сэтгэл зүйч*

Эдийн засгийн шинжилгээний хэлтэс

- ❖ *Эдийн засагч*
- ❖ *Нягтлан бодогч*

Инженер-техникийн шинжилгээний газар

- ❖ *Мэдээлэл технологийн инженер, программ хангамжийн инженер⁴⁶*

⁴⁶ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн а/232 дугаар тушаал.

ЧАДВАРЛАГ БОЛОВСОН ХҮЧИН



Мөн шүүхийн шинжилгээний байгууллагад өнөөгийн байдлаар төрөл бүрийн тусгай мэдлэг, мэргэжилтэй албан тушаалтай ажиллаж байна. Өнөөгийн байдлаар хийж буй шинжилгээний төрөл тухайн шинжээчийн мэргэжил, тусгай мэдлэгээс шууд хамаарч байна.

Шүүх шинжилгээний байгууллага нь өнөөдөр шинжилгээгээр шийдвэрлэж байгаа асуудлууд байгаа боловч шийдвэрлэж чадахгүй байгаа нийгмийн шаардлага болсон асуудлууд их байна. Үүнд

№	Мэргэжлийн чиглэл	Шинжээчээс асуусан асуулт
1	Хэл шинжлэл	Орчуулга үнэн зөв хийгдсэн эсэх
2	Хөдөлмөр хамгаалал	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, эрүүл мэндээ хангах үүргээ биелүүлсэн эсэх
3	Авто зам	Замын далангийн технологийн эвдрэлийн шалтгаан тогтоох
4	Инженер техник	Өрөмдөгч багаж стандарт шаардлага хангаж байгаа эсэх
5	Барилгын инженер	Барилга хоорондын зай стандарт хангаж байгаа эсэх, ямар технологиор хийгдсэн эсэх, барилгын засвар үйлчилгээнд хийх зардал, үнэлгээг тогтоох, авто зогсоолд нийт хичнээн машин зогсох боломжтой вэ
6	Газар	Газрын байршил кадастр давхацсан эсэх
7	Хими	Ахуйн газны агаарт дэгдэх нөлөөллийг тогтоох

8	Хөрөнгийн үнэлгээ	Дүнзэн байшин, дутуу баригдсан гражийн материалууд тус бүрийн үнэлгээ, ажлын хөлс, байшинг дахин нураах, барих зардал тээврийн хөлс зэргийн зах зээлийн үнэлгээг тогтоох
9	Гамшиг судлал	Гал гарсан шалтгааныг тогтоох
10	Материал судлал	Усан сангийн материал ямар төрлийн материал вэ
11	Хор судлал	Хорны нөлөөлөх түвшин, ямар төрлийн эм болох
12	Амьтан судлал	Адууны гарал үүслийг тогтоох
14	Урлаг судлал	Уран зургийн эх хувь зураг нь аль нь вэ, өөрчлөлт байгаа эсэх
15	Геологи, уул уурхай	Хөөргөний чулуу үнэт чулуу мөн эсэх

Дээрх судалгаанаас харахад шүүх шинжилгээний байгууллагад хийдэггүй шинжилгээг хийлгүүлэхээр ирүүлсэн шийдвэрт бид өнөөдрийн хүчин, чадал, технологи, хүний нөөц /тусгай мэдлэг бүхий шинжээч/-ийг ажиллуулах эгнээгээ өргөтгөх шаардлагатай ирээд байгааг харуулж байна.

Зарим оронд хийгдэж буй шүүхийн шинжилгээний төрөл:

Гүрж

Дотоод хэргийн яамны Шүүх шинжилгээний байгууллагаас гадна Levan Samkharauli-ийн нэрэмжит Шүүх шинжилгээний үндэсний товчоонд дараах төрлийн шинжилгээ хийдэг:

- ❖ Авто-техник, төмөр зам, агаарын-техникийн шинжилгээ
- ❖ Галын техникийн шинжилгээ
- ❖ Техник инженерийн шинжилгээ
- ❖ Бараа судлалын шинжилгээ
- ❖ Мансууруулах бодис, хор судлал, хар тамхины шинжилгээ
- ❖ Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээ
- ❖ Тамхи, согтууруулах ундаа, согтууруулах бус

ундааны шинжилгээ

- ❖ Газрын тосны бүтээгдэхүүний шинжилгээ

Оросын Холбооны Улс

Оросын Холбооны Улсын ДХЯ-ны харьяа криминалистикийн шинжилгээний төвд манай улсад хийгдэж байгаа уламжлалт шинжилгээнээс гадна

- ❖ Үнэр судлал
- ❖ Хөрс, ургамал, эрдсийн шинжилгээ
- ❖ Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээ

Хувийн лабораториудад

- ❖ үнэлгээний,
- ❖ инженер техникийн,
- ❖ бараа судлалын,
- ❖ барилга угсралтын,
- ❖ электроник

Унгар Улс

- ❖ Морфологи, органик бус бодисын шинжилгээ
- ❖ Галын техникийн шинжилгээ
- ❖ Согтууруулах бодисын төрөл тогтоох шинжилгээ
- ❖ Хор судлал

Хонгконг Улс

- ❖ Биохимийн шинжилгээ
- ❖ Эмийн бодисын шинжилгээ
- ❖ Хор судлалын шинжилгээ
- ❖ Сэтгэц судлалын шинжилгээ

Энэ бүх статистик судалгаа, болон бусад улс орны жишээн дээрээс харахад шүүхийн шинжилгээний байгууллагын хөгжлийн чиг хандлага орчин үеийн техник технологиос гадна хүний нөөц /тусгай мэдлэг бүхий шинжээч/-ийг бүрдүүлэх гаднын бусад улс оронд хийгдэж буй зарим төрлийн шинжилгээг хийдэг болох, бүтэц, орон тоог нэмэх, шинэ төрлийн шинжилгээний төрлийг нэмэгдүүлэх, нийгэмд хэрэгцээ шаардлагатай байгаа шинэ төрлийн асуудлуудыг шинжилгээгээр шийдвэрлэдэг болох, харуут бус байх зарчмыг баримтлан ажиллах шаардлага өнөө цаг үед ирээд байна.

Дүгнэлт

- Шүүхийн шинжилгээний байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичгийн зорилго бүрэн хангагдахгүй байна.
- Албан хаагчдын ажлын ачаалал эрс өссөн, цаашид орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- Цаашид шинэ төрлийн шинжилгээний тоо улам өсөх хандлагатай байна.
- Шүүхийн шинжилгээний байгууллагын хүний нөөцийг бэлтгэх сургалтын тогтолцоог дэлхийн жишигт нийцүүлэх шаардлагатай байна.
- Хөгжингүй орнуудын шүүхийн шинжилгээний байгууллагын түвшинд хүрэхүйц бүтэц, боловсон хүчин, техник тоног төхөөрөмжтэй болох шаардлагатай байна.

Санал

- Хүний нөөцийн бодлогын баримт бичгийн зүйл заалтыг нарийвчлан боловсронгуй болгох ажлын хэсгийг байгуулан ажиллах.

- Шүүхийн шинжилгээний байгууллагад ойрын болон урт хугацаанд хийгдэх шинжилгээний хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох.
- Шаардлагатай мэргэжил, мэдлэгтэй албан хаагчдын хүний нөөцийг бэлтгэх, байгалийн шинжлэх ухаанд суурилсан тусгай мэдлэг бүхий албан хаагчдыг ажиллуулах асуудлыг бодлогоор төлөвлөх.

Ашигласан материал

- 1) ШШҮХ. (2022). *Шүүх шинжилгээний тухай хууль*. Улаанбаатар.
- 2) (2016). *Хүний нөөцийн хөтөлбөр, төлөвлөлт*. Улаанбаатар.
- 3) ШШҮХ. (2018). *Бодлогын баримт бичиг*. Улаанбаатар.
- 4) Нямдорж, Ж. (2015). *“Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх онол, практикийн асуудал, шийдвэрлэх арга зам” магистрын судалгааны ажил*. Улаанбаатар.
- 5) Одбаатар, Б. (2016, хууд. 112). *Байгууллагын удирдлага: онол, арга зүй*. Улаанбаатар.
- 6) Төмөрбаатар, Р. (2015) *“Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох арга зам” магистрын судалгааны ажил*. Улаанбаатар.
- 7) Цэцэгмаа, Ц. (2001, хууд. 205). *Хүний нөөцийн менежмент*. Улаанбаатар.
- 8) Энхчулуун, Б. (2014, хууд. 86). *“Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн удирдлага, зарим асуудал” магистрын судалгааны ажил*. Улаанбаатар.
- 9) Эрдэнэхүү, Б. (2016). *“Шүүхийн шинжилгээний байгууллагын хүний нөөцийн удирдлагын тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” магистрын судалгааны ажил*. Улаанбаатар.
- 10) Leoyd L.Byars. (2010). Human Resource management,
- 11) Солдатова, Ирина Анатольевна. (2010, С. 156). *Управление человеческими ресурсами организации в условиях инновационного развития. Докторская диссертация*. Москва.

Цахим эх сурвалж:

- 1) www.nif.gov.mn
- 2) www.legalinfo.mn
- 3) www.google.mn